



ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 07 сарын 25 өдөр

Дугаар А/448

Эрдэнэт

Өмчлөх эрх олгох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2.1.2/г/, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчийн үндсэн хөрөнгийн дуудлагын худалдааг зохион байгуулах журам”-ын 8.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2017 оны 07 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан дуудлагын худалдаагаар худалдагдсан аймгийн Цагдаагийн газарт ашиглаж байсан Хьюндэй Соната-4 маркийн суудлын авто машиныг иргэн Н.Отгонбат, Тоёота Ланд круйзер-105 маркийн суудлын авто машиныг иргэн Э.Ганзориг, Хьюндэй Верна аксент маркийн суудлын авто машиныг иргэн Б.Түвшин-Эрдэнэ, Аудитын газарт ашиглаж байсан Тоёота Прадо-95 маркийн 99-52 ОРА улсын дугаартай суудлын авто машиныг иргэн Д.Цогбадрах, Хүнс, хөдөө аж ахуй, жижиг дунд үйлдвэрийн газарт ашиглаж байсан УАЗ-2206933 маркийн 10-95 ОРХ улсын дугаартай суудлын авто машиныг иргэн Э.Даваасүрэн, Форланд потон маркийн 12-14 ОРА улсын дугаартай суудлын авто машиныг иргэн Т.Гончиг, Боловсрол соёл, урлагийн газарт ашиглаж байсан Хьюндэй Грейс маркийн 60-23 ОРХ улсын дугаартай суудлын авто машиныг иргэн Л.Дашням, Бүсийн оношлогоо эмчилгээний төвд ашиглаж байсан УАЗ-Фургон маркийн 38-52 ОРХ улсын дугаартай суудлын авто машиныг иргэн Т.Галмыгмар, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газарт ашиглаж байсан УАЗ-Хантер маркийн 04-94 ОРХ улсын дугаартай суудлын авто машиныг иргэн Б.Буянбат, “Эрдэнэт Ус ДТС” ОНӨХК-д ашиглаж байсан Тоёота Ланд круйзер-80 маркийн 04-04 ОРА суудлын авто машиныг иргэн Д.Эрдэнэцэцэг, “Мөнхсүндрэл” ӨЭМТ-д ашиглаж байсан Honda CRV маркийн 58-13 ОРХ улсын дугаартай суудлын авто машиныг иргэн С.Эрдэнэбат нар тус тус худалдан авсан тул өмчлөх эрх олгосугай.

2.Дээрх авто машинуудыг Орон нутгийн өмчийн нэгдсэн бүртгэлээс хасч, шинэ өмчлөгчид хүлээлгэн өгөхийг Орон нутгийн өмчийн газарт, байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл, балансаас хасахыг холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



С.БАТЖАРГАЛ

D:(Zahiramj) A-4 doc

0200002024